



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 05-р сарын 01-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Компанийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.5 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 01-ний өдрийн хурлын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол базальт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Лхагважавын Ариунболд /ЧР65010678/-ыг сонгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Компанийн тухай хууль, компанийн засаглалын кодекс, компанийн дүрэмд заасан эрх үүргийг хэрэгжүүлэн Төлөөлөн удирдах зөвлөлийг ур чадвар, мэдлэг туршлага, хараат бус байдлыг зохистойгоор хангасан алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байхад анхаарч ажиллахыг ТУЗ-ийн дарга /Л.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 05-р сарын 01-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх
хорооны бүрэлдэхүүнийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, 81.5, Компанийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.16 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 01-ний өдрийн хурлын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол базальт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
Хорооны дарга: П.Нямдорж /хараат бус гишүүн/
Гишүүд: Г.Ганзориг /ердийн гишүүн/
Ч.Зоригтбаатар /хараат бус гишүүн/
2. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, идэвхи санаачлагатай ажиллахыг Нэр дэвшүүлэх хорооны дарга /П.Нямдорж/-д үүрэг болгосугай.
3. Компанийн залгамж халааны бодлогын баримт бичгийг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, үйл ажиллагаанд дагаж мөрдөх хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг Нэр дэвшүүлэх хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛЪТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 05-р сарын 01-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын
хорооны бүрэлдэхүүнийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, 81.6, Компанийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.16 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 01-ний өдрийн хурлын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол базальт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
Хорооны дарга: Ш.Энхтөр /хараат бус гишүүн/
Гишүүд: П.Сайнбилэг /ердийн гишүүн/
П.Нямдорж /хараат бус гишүүн/
2. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, идэвхи санаачлагатай ажиллахыг Цалин урамшууллын хорооны дарга /Ш.Энхтөр/-д үүрэг болгосугай.
3. Компанийн цалин урамшууллын бодлогын баримт бичгийг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах, үйл ажиллагаанд дагаж мөрдөх хэрэгжилтийг нь хангаж ажиллахыг Цалин урамшууллын хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 05-р сарын 01-ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдлийн удирдлагын хороо байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1, Компанийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.16 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 01-ний өдрийн хурлын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол базальт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд компанийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн чиглэлийг хамаарч хүлээж болох эрсдлийн төрөл, хэмжээ хязгаарыг тооцоолох, илрүүлэх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий Эрсдлийн удирдлагын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Ч.Зоригтбаатар /хараат бус гишүүн/

Гишүүд: Л.Ариунболд /ердийн гишүүн/

А.Энхгэрэл /ердийн гишүүн/

Б.Шаравсамбуу /ердийн гишүүн/

П.Нямдорж /хараат бус гишүүн/

2. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексыг баримтлан Компанийн эрсдлийн удирдлагын баримт бичиг болон Эрсдлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журмыг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулахыг Эрсдлийн удирдлагын хорооны дарга /Ч.Зоригтбаатар/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 05-р сарын 01-ны өдөр

№ 09

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын
хорооны бүрэлдэхүүнийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, 81.4, Компанийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.16 дахь заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 05 сарын 01-ний өдрийн хурлын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол базальт ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Ч.Зоригтбаатар /хараат бус гишүүн/

Гишүүд: Б.Шаравсамбуу /ердийн гишүүн/

Ш.Энхтөр /хараат бус гишүүн/

2. Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон Аудитын хорооны үйл ажиллагааны журамд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, идэвхи санаачлагатай ажиллахыг Аудитын хорооны дарга /Ч.Зоригтбаатар/-д үүрэг болгосугай.
3. Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулан, үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг Аудитын хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.АРИУНБОЛД